

Маягт 1

“ХАРХОРИН” ХУВЬЦААТ КОМПАНИ

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг ургийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

Тайлганах хугацаа /Жишиг нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/	2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын буртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	“Хархорин” ХК Улсын буртгэлийн дугаар: 1010001006 Үнэт цаасны код: ННН Утасны дугаар: 99993800, 89066318
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Хөдөө аж ахуй, газар тариалан Чацаргана тариалах, Чацаргана болон бусад модлог ургамлын суулгац бойжуулах
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	“Шинэ Их Тэрбум Аудит” ХХК Тусгай зөвшөөрлийн огноо: 2017 оны 05-р сарын 10-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	539,515 ширхэг
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Б.Ганбат ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
1. Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	“Шинэ Их Тэрбум Аудит” ХХК-ийн зүгээс үнэт цаас гаргагчийн 2023 оны санхүүгийн тайланда аудитын дүгнэлт хийсэн бөгөөд тус аудитын тайлангийн дагуу: Санхүүгийн байдлын үзүүлэлт Эргэлтийн хөрөнгийн дүн – 6,177.9 сая төгрөг Эргэлтийн бус хөрөнгийн дүн - 2,766.7 сая төгрөг Нийт хөрөнгийн дүн – 8,944.6 сая төгрөг

		<p>Богино хугацаат өр төлбөрийн дүн – 10,248.0 сая төгрөг Урт хугацаат өр төлбөрийн дүн - 0.0 сая төгрөг Өр төлбөрийн нийт дүн – 10,248.0 сая төгрөг Эзэмшигчдийн өмчийн дүн - (1,303.4) сая төгрөг Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн – 8,944.6 сая төгрөг</p>
	<i>Орлогын тайлан</i>	<p>Үйл ажиллагааны орлого – 539.0 сая төгрөг Борлуулалтын өртөг – 668.0 сая төгрөг Нийт ашиг (алдагдал) – (128.9) сая төгрөг Бусад орлого – 166.8 сая төгрөг Бусад зардал – 104.9 сая төгрөг Татвар төхөхийн өмнөх ашиг (алдагдал) - (67.0) сая төгрөг Татварын дараах ашиг (алдагдал) - (67.0) сая төгрөг</p>
	<i>Өмчийн өөрчлөлтийн тайлан</i>	<p>Өмч - 836.2 сая төгрөг Хуримтлагдсан ашиг - (2,139.6) сая төгрөг Нийт дүн - (1,303.4) сая төгрөг</p>
	<i>Мөнгөн гүйлгээний тайлан</i>	<p>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ Мөнгөн орлогын дүн – 534.4 сая төгрөг Мөнгөн зарлага – 540.0 сая төгрөг Цэвэр мөнгөн гүйлгээ - 5.6 сая төгрөг</p> <p>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ Мөнгөн орлогын дүн - 0.0 сая төгрөг Мөнгөн зарлага - 0.0 сая төгрөг Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн - 0.0 сая төгрөг</p> <p>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ Мөнгөн орлого - 0.0 сая төгрөг Мөнгөн зарлага - 0.0 сая төгрөг Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн - 0.0 сая төгрөг</p> <p>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ 5.6 сая төгрөг</p>

1.1.	<i>Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт</i>
	<p>“Шинэ Их Тэрбум Аудит” ХХК-ийн зүгээс үнэт цаас гаргагчийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтээр:</p> <p>“Санхүүгийн тайлангууд нь компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна”</p> <p>/Аудитын тайлангийн хувийг хавсаргав/.</p>
1.2.	<i>Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидалыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/</i>
	Аудитын захидалын хуулбарыг хавсаргав.
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсон үнэлгээ, цаасиод авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл

2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	<p>2023 оны 12-р сарын 31-ний байдлаарх санхүүгийн харьцаанууд:</p> <ul style="list-style-type: none"> • Нийт хөрөнгийн өгөөж /ROA/: -0.007 • Хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж /ROE/: -0.080 • Нийт хөрөнгийн эргэц /ROTA/: 0.060 • Нэгж хувьцааны өгөөж /EPS/: -124.21 • Үнэ ашгийн харьцаа (P/E Ratio): -10.95
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> • Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа: 0.06 • Үнэмлэхүй хөрвөх хөрөнгийн харьцаа: 0.0
2.3.	<p>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нолоолол, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</p>	<p>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гол нөлөө үзүүлсэн гадаад хүчин зүйл:</p> <p>2023 оны зун 07-р сард Хархорин сумын төвөөр дайрч өнгөрсөн хүчтэй борооноор үер бууж, Хархорин сумын үерийн даланг дамжин орж ирсэн их хэмжээний үерийн ус, лаг, шавар “Хархорин” ХК-ийн усжуулалтын сувгийг хэд хэдэн газарт эвдэж, бөглөрөл үүсгэсэн. Үүнээс үүдэн үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд маш чухал үүрэг гүйцэтгэдэг усжуулалтын сувгийн үйл ажиллагаа бүрэн зогсож, компанийн чацаарганын талбай болон мод бойжуулгын аж ахуйн усалгаа доголдсон. Компани нь дан өөрийн хүчээр сувгийг хуримтлагдсан лаг шавар, хог хаягдлаас цэвэрлэх боломжгүй байсан бөгөөд эрх бүхий байгууллагууд, үүнд Хархорин сумын ЗДТГ, Онцгой байдлын алба болон бусад байгууллагуудад хандаж, туслалцаа хүсэж албан бичиг илгээсэн. Гэвч шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй аваагүй, ямар нэгэн туслалцаа үзүүлээгүй.</p> <p>Дээрх шалтгаанаас үүдэн 2023 онд компани нь чацаарганын ургацаа бүрэн алдсан. Мөн мод бойжуулгын аж ахуйд маш их хэмжээний хохирол учирсан.</p> <p>Хархорин сумын үерийн даланг анхнаасаа буруу, алдаатай төлөвлөсөн бөгөөд улсын хөрөнгөөр хийгдсэн тухайн ажлын гүйцэтгэгч компаниудын буруутай ажиллагаанаас үүдэн жил тутам манай компанийн усжуулалтын суваг үерийн ус, лаг шаварт эвдрэх, бөглөрөх асуудал гардаг. Бид тухай бүр холбогдох албан байгууллагуудад мэдэгдэж, сувгийг цэвэрлэх, асуудлыг шийдвэрлэж өгөх хүсэлтийг тавьдаг. Гэвч өдийг хүртэл ямар нэгэн ажил хийгдээгүй, компани хохирсоор байна.</p> <p>Бүтээгдэхүүний нэр төрөлд гарсан өөрчлөлт:</p> <p>“Хархорин” ХК нь тайлант хугацаанд үндсэн бүтээгдэхүүн болох чацааргана жимс, чацааргана болон бусад төрлийн модлог ургамлын суулгацаас өөр шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлээгүй, гаргаагүй болно.</p> <p>2024 онд хийхээр төлөвлөж байгаа ажил, арга хэмжээ: “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд зөвхөн чацааргана төдийгүй бусад модлог ургамлын суулгацыг бойжуулж дотоодын зах зээлд</p>

		нийлүүлэх ажлыг үргэлжлүүлэх, борлуулалтад эзлэх хувийг нэмэгдүүлэх
2.4.	<i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/</i>	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагч нь өөрийн санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ хийгээгүй болно.
2.5.	<i>Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;</i>	Тайлант хугацаанд “Хархорин” ХК нь банк, санхүүгийн байгууллагуудаас шинээр зээл аваагүй болно. Баталгаа болон зээлийн барьцаа хөрөнгийн тухайд: 2019 оноос хойш “Хархорин” ХК-ийн өмчлөл, эзэмшилийн нэр бүхий хөрөнгө нь Монгол Улсын хуулийн этгээд “Хархорин чацаргана” ХХК-ийн Худалдаа хөгжлийн банкнаас авсан зээлийн барьцаанд байршиж байгаа.
3.	<i>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</i>	“Хархорин” ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 07 сарын 27-ны өдрийн 03/2023, 04/2023 дугаар шийдвэрээр “Хархорин чацаргана” ХХК-ийн Худалдаа хөгжлийн банканаас авсан зээлийн барьцаанд байршуулсан байгаа үл хөдлөх хөрөнгө болон газар эзэмших эрхийг үргэлжлүүлэн барьцаалахаар шийдвэрлэсэн болно. Зээлдэгч нь тус банкан дээрх өөрийн зээлийн нөхцөлд өөрчлөлт оруулсан болно.
4.	<i>Цалин урамшууллын мэдээлэл</i>	Тайлант хугацаанд ТУЗ-ийн гишүүдэд ямар нэгэн цалин урамшуулал олгоогүй болно. Ажилчдын цалинг цаг хугацаанд нь олгох асуудал дээр удирдлагын зүгээс анхаарч, 2023 онд цалинг цаг тухайд нь олгож байсан. Гэвч дээр дурдсан шалтгаанаар ургац алдсантай холбоотойгоор компанийн санхүүгийн нөхцөл байдлад хүндрэл учирч, 2023 оны 11, 12-р саруудын цалинг олгоход асуудал гарсан. Гэсэн хэдий ч компанийн удирдлагын зүгээс ажилтан ажиллагсдын цалинг цаг тухайд нь тавьж байх, хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах дээр онцгой анхаарал хандуулан ажилласан.
5.	<i>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</i>	“Хархорин” ХК нь тайлант хугацаанд өөрийн үйл ажиллагаандаа Компанийн засаглалын кодекс, үүнтэй холбогдуулан гаргасан дотоод дүрэм журмуудыг баримтлан ажилласан болно. СЗХ-ны 2022 оны 03 сарын 23 өдрийн 145 дугаар тогтоолоор Компанийн засаглалын кодексийг шинэчлэн баталсантай холбоотойгоор тус компани нь Компанийн засаглалтай холбоотой өөрийн дотоод дүрэм журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа. Компанийн засаглалын тайланг цаг тухайд нь гаргаж МХБ, СЗХ-д хүргүүлэн ажилласан. 2024 онд компанийн засаглалтай холбоотой дүрэм журмуудыг боловсронгуй болгох, шинэчлэх тад дээр анхаарч ажиллана.
6.	<i>Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл</i>	“Хархорин” ХК-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэл болох чацаргана тариалах, чацарганын болон бусад модлог ургамлын суулгац бойжуулахтай холбоотой зах зээлийн эрсдэлүүд нь: Дотоодын өрсөлдөөн, зах зээл дээрх эрэлт, нийлүүлэлтийн эрсдэл, төр засгийн зүгээс үзүүлэх дэмжлэг, бодлого зохицуулалтын эрсдэлүүд нь үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц эрсдэлүүд болно.


	“Хархорин” ХК нь өөрийн талбай дээрээс хураасан чацарганын жимсийг үндэсний чацаргана боловсруулах, чацарганаар бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрүүдэд бөөнөөр нийлүүлдэг. Чацаргана жимсийг түүхийгээр нь гадаадад экспортлоход ихээхэн хүндрэлтэй. Монгол улсын өөрийн дотоодын чацаргана жимсний бүтээгдэхүүний хэрэглээ хязгаарлагдмал тул чацаргана боловсруулах үйлдвэрүүд нь чацаргана жимсийг их хэмжээгээр худалдан авах боломжгүй. Түүнчлэн сүүлийн жилүүдэд чацарганыг жижиг ААН, хувь хүмүүс ихээр тариалах болсон. Эдгээр шалгаанаас үүдэн үнэт цаас гаргачийн хувьд дотоодын түүхий чацаргана жимсний нийлүүлэлт их, эрэлт хязгаарлагдмал шалгаанаар чацаргана жимсний үнэ буурах, их хэмжээний ургац хураасан тохиолдолд үйлдэрүүдэд нийлүүлж чадахгүй байх зэрэг эрсдэлүүд байгаа.
7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшилийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/
	Тайлант хугацаанд “Хархорин” ХК-ийн 5% ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдэд ямар нэгэн өөрчлөлт гараагүй болно. УЦТХТ-с гаргуулсан хувьцаа эзэмшигчдийн судалгаагаар “Хархорин” ХК-ийн нийт 539,515 ш (100%) энгийн хувьцааг нийт 584 хувьцаа эзэмшигч эзэмшиж байгаагаас 5% ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчид нь дараах болно. Үүнд: 1. Иргэн С.Пүрэв - 377,660 (70.0%) 2. Монгол Улсын хуулийн этгээд “Селус номадс” ХХК - 102,521 ш (19.0%)
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжсийж эхэлснээс хойши дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл “Хархорин” ХК нь тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа болон бусад төрлийн үнэт цаас гаргаагүй болно.
9.	Ногдол ашигийн мэдээлэл
	“Хархорин” ХК нь тайлант хугацаа буюу 2023 оны 01-р сарын 01-с 2023 оны 12-р сарын 31-ний өдрийн хооронд ногдол ашиг хуваарилаагүй болно. Түүнчлэн “Хархорин” ХК нь ТУЗ-ийн 2024.02.19 өдрийн 01/2024 тогтоолын дагуу 2023 оны ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн болно.
10.	Үнэт цаас гаргагчаас тайланда хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл Нийгмийн хариуцлагын хүрээний ажил хийгээгүй болно.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Пүрэвийн УЧРАЛ

Албан тушаал: “Хархорин” ХК-ийн гүйцэтгэх

захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч


ХАРХОРИН
Гарын үсэг: **ХК**
(Тамга/тэмдэг)
TTB2042-4-2015471

Овог, нэр: Д.Дашдулам

Албан тушаал:


УЛААНБААТАР ХОТ
“ШИНЭ ИХ ТЭРБУМ АУДИТ” ХХК-ийн захирал


ШИНЭ ИХ
ТЭРБУМ АУДИТ
ХХК
Гарын үсэг:
1116216172-4-6900797
(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Баттогтох Ганбат

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг:


Огноо: